

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 3 сарын 24 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨГДӨХ НӨХЦЛИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3-р сарын 21-ны өдрийн 3/1066 тоот тогтоол, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3-р сарын 21-ны өдрийн 3/1066 тоот тогтоолоор хэрэглээний зээл олгох зохицуулалтад хамаарах харьцааг бууруулж, өр орлогын харьцаа болон суудлын автомашин худалдан авах зээл, үнэлгээний харьцааг тус тус 60 хувиас ихгүй байхаар тогтоосны дагуу компанийн “Зээлийн бүтээгдэхүүний нөхцөл”-д өөрчлөлт орсныг Хавсралт №1-р шинэчлэн баталсугай.
2. Дээрх журам, нөхцөлийг 2025 оны 3-р сарын 27-ны өдрөөс мөрдөн ажиллахыг Гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэг, “Цамба” салбарын захирал Ц.Билэг-Өрнөх, “22 Авто цогцолбор” салбарын захирал М.Уянга нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ